
ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 08-р сарын 07

Тендер шалгаруулалтын нэр: “Монголросцветмет” ТӨҮГ-т СБШ-250 өрмийн штанг нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/201901221

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос СБШ-250 өрмийн штанг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэгүй авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: *Сүүлийн 2 жилийн аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-иас багагүй байна*

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Шаардлагагүй.**

Тендерийн хамт **1,813,460** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2019 оны 09-р сарын 09-ний өдрийн 10:00 цагаас** өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба тендерийг **2019 оны 09-р сарын 09-ний өдрийн 10:10 цагт** цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 508 тоот өрөө, утас: 450060 + 186

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ